



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал даатгал” ХХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 6,243,016 /зургаан сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Мандал даатгал” ХХК-ийн нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 4,682,262 /дөрвөн сая зургаан зуун наян хоёр мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “ҮЦГХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 1,560,754 /нэг сая таван зуун жаран мянга долоон зуун тавин дөрөв/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 4,800 /дөрвөн мянга найман зуу/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Мандал даатгал” ХХК /Б.Жавхлан/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Мандал даатгал” ХХК /Б.Жавхлан/-д мэдэгдсүгэй.

5. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “ҮЦГХТ” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 4-т заасан нийтэд санал болгон худалдах хувьцааг 100 /нэг зуу/ хувийг анхдагч зах зээлд арилжаалж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /Э.Амарбаясгалан/-д анхааруулсугай.

8. “Мандал даатгал” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Мандал даатгал” ХХК /Б.Жавхлан/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /Э.Амарбаясгалан/, “Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс” ХХН /Г.Батбаяр/, “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/, “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК /Б.Осоргарав/-д тус тус анхааруулсугай.


10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 8. дугаар сарын 29-ний
өдрийн 222 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны эзэмшлийн хувь
1	“Голомт Файнэншил Групп” ХХК	2,550,000	40.85%
2	“Юу Эм Си Капитал” ХХК	2,132,262	34.15%
	Нийт дүн	4,682,262	75.00%